



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 9/178

Хархорин сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Эрдэнэзуу гудамж 120 тоотод иргэн Ч.Хоролгүрийн худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв цогцолборын зориулалтаар эзэмшиж байгаа 6209002035 нэгж талбарын дугаартай 2160м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.Газар эзэмшигч Ч.Хоролгүр-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Ч.Хоролгүр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100355